

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн биеийн тамир, спортын хорооны 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/185/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelqerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Гурван Хөх Морьт Аудит ХХК
Гүйцэтгэх захирал: Н.Отгончимэг
Утас:99051815 Цахим хаяг: gurvankhukhmoritllc@gmail.com

Аудитор: Ш.Саранчимэг
Утас:99834361 Цахим хаяг: gurvankhukhmoritllc@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ХОРООНЫ ДАРГА
Б.БАЯРСАЙХАН ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/244
танай _____-ны № _____-Т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Биеийн тамир, спортын хорооны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

"Хөвсгөл аймгийн Засаг даргын захирамжаар Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг "Монголд Зочлох жил" болгон зарласантай холбогдуулан "Эвент арга хэмжээ зохион байгуулах, аялал жуулчлалын чиглэлээр гадаад, дотоодод үзэсгэлэнд оролцох, Спортын тодорхой төрлүүдээр Өсвөр үеийн шигшээ багийн үйл ажиллагааг эхлүүлж байгаатай холбогдуулан Засаг даргын нөөц хөрөнгөөс 201,695.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн захирагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 96.2 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6725 921984

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	152,876,324.00	161,745,702.41
33	АВЛАГА	-	103,289.41
335	Бусад авлага	-	103,289.41
3351	Байгууллагаас авах авлага		103,289.41
35	БАРАА МАТЕРИАЛ	152,876,324.00	161,642,413.00
351	Түүхий эд материал	57,069,274.00	61,888,313.00
35110	Тусгай зориулалттай материал	57,069,274.00	61,888,313.00
354	Хангамжийн материал	95,807,050.00	99,754,100.00
35410	Бичиг хэргийн материал	728,350.00	981,500.00
35420	Аж ахуйн материал	3,174,000.00	9,951,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,562,400.00	4,318,500.00
35440	Түлш, шатах тослох материал	5,000,000.00	5,500,000.00
35450	Барилгын засварын материал	27,661,400.00	27,652,900.00
35470	Бусад хангамжийн материал	54,680,900.00	51,350,200.00
35600	Мал амьтад		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,962,185,729.18	3,764,570,582.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,962,185,729.18	3,764,570,582.82
392	Биет хөрөнгө	2,981,106,979.18	2,783,866,832.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,658,715,441.19	2,658,715,441.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	(354,303,420.48)	(438,566,819.04)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,600,000.00	33,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(17,266,666.79)	(22,866,666.83)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	101,978,275.82	126,108,075.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	(35,679,003.54)	(67,721,799.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,549,500.00	53,640,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,690,858.22)	(10,522,473.72)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,176,772,812.00	1,176,772,812.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(607,569,100.80)	(725,291,736.96)
393	Биет бус хөрөнгө	981,078,750.00	980,703,750.00
39301	Программ хангамж	2,050,000.00	2,050,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,143,750.00)	(1,518,750.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	980,172,500.00	980,172,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,115,062,053.18	3,926,316,285.23
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,438,970.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,438,970.00
413	Өглөг	-	1,438,970.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		1,288,070.00
4136	Бусад өглөг	-	150,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг		150,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,115,062,053.18	3,924,877,315.23
51	Засгийн газрын хувь оролцоо	2,149,478,579.00	2,149,478,579.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,149,478,579.00	2,149,478,579.00
51101	Өмч: - төрийн	2,149,478,579.00	2,149,478,579.00
512	Хуримтлагдсан үр дүн	716,078,078.45	525,893,340.50
51210	Өмнөх үеийн үр дүн	749,455,945.67	716,078,078.45

51220	Тайлант үеийн үр дүн	(33,377,867.22)	(190,184,737.95)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,249,505,395.73	1,249,505,395.73
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,115,062,053.18</u>	<u>3,926,316,285.23</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,026,585,600.00	1,380,993,726.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,365,000.00	22,758,176.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,365,000.00	22,758,176.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,365,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,365,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
120009	Бусад орлого		278,176.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ		18,480,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		4,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,022,220,600.00	1,358,235,550.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	673,425,400.00	907,978,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	673,425,400.00	907,978,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	111,295,200.00	215,256,650.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	96,295,200.00	201,695,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00	8,076,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		5,485,650.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	237,500,000.00	235,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	237,500,000.00	235,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,059,963,467.22	1,571,178,463.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,059,963,467.22	1,571,178,463.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,045,816,331.37	1,554,209,032.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	380,356,962.31	700,583,551.69
210101	Үндсэн цалин	235,295,454.99	455,596,555.58
210102	Нэмэгдэл	46,433,670.27	116,510,196.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,122,518.18	53,792,500.00
210104	Урамшуулал	57,505,318.87	74,684,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,083,437.22	88,089,845.31
210201	Тэтгэврийн даатгал	32,812,897.38	59,769,977.66
210202	Тэтгэмжийн даатгал	3,850,634.98	7,019,032.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,045,308.01	3,793,795.35
210204	Ажилгүйдлийн даатгал	761,326.95	3,496,316.07
210205	Эрүүл мэндийн даатгал	7,613,269.90	14,010,724.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	183,426,042.62	190,088,069.77
210301	Гэрэл, цахилгаан	7,977,246.40	10,936,246.00
210302	Түлш, халаалт	168,317,518.22	171,999,999.77
210303	Цэвэр, бохир ус	7,131,278.00	7,151,824.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	62,727,970.00	62,788,718.94
210401	Бичиг хэрэг	7,282,650.00	4,002,850.00
210402	Тээвэр, шатахуун	42,213,300.00	53,184,500.00

Хөвсгөл аймгийн биеийн тамир, спортын хорооны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,337,500.00	1,177,918.94
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	280,000.00	550,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,904,520.00	3,873,450.00
210408	Бараа материал акталсны зардал	4,710,000.00	-
2105	Нормативт зардал		11,442,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		-
210502	Хоол, хүнс		11,442,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,432,800.00	14,311,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		-
210604	Урсгал засвар	46,432,800.00	14,311,600.00
2107	Томилолт, зочны зардал	2,412,000.00	2,502,000.00
210702	Дотоод албан томилолт	2,412,000.00	2,502,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,003,702.00	4,201,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,000.00	845,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540000	529,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	117,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,500.00	17,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	32,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	476,000.00	485,000.00
210807	Газрын төлбөр	2,755,202.00	2,174,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	318,373,417.22	480,201,246.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	206,915,500.00	232,365,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	111,457,917.22	247,835,446.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,147,135.85	16,969,431.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,400,000.00	10,067,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		7,321,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,400,000.00	2,746,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,883,721.65
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		5,883,721.65
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,017,910.23
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		441,000.23
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		576,910.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,747,135.85	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,747,135.85	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(33,377,867.22)</u>	<u>(190,184,737.95)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(33,377,867.22)</u>	<u>(190,184,737.95)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
С01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,149,478,579.00	1,249,505,395.73	749,455,945.67	4,148,439,920.40
С03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,149,478,579.00	1,249,505,395.73	749,455,945.67	4,148,439,920.40

C07	Тайлант үеийн үр дүн			-33,377,867.22	(33,377,867.22)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,149,478,579.00	1,249,505,395.73	716,078,078.45	4,115,062,053.18
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,149,478,579.00	1,249,505,395.73	716,078,078.45	4,115,062,053.18
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,149,478,579.00	1,249,505,395.73	716,078,078.45	4,115,062,053.18
D08	Тайлант үеийн үр дүн			(190,184,737.95)	(190,184,737.95)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,149,478,579.00	1,249,505,395.73	527,194,303.59	3,924,877,315.23

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,026,585,600.00	1,358,513,726.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,365,000.00	278,176.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,365,000.00	278,176.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,365,000.00	278,176.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,365,000.00	-
120009	Бусад орлого		278,176.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,022,220,600.00	1,358,235,550.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	673,425,400.00	907,978,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	673,425,400.00	907,978,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	111,295,200.00	215,256,650.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	96,295,200.00	201,695,000.00
131103	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00	8,076,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		5,485,650.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	237,500,000.00	235,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	237,500,000.00	235,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	966,446,409.15	1,352,863,926.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	966,446,409.15	1,352,863,926.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	963,646,409.15	1,335,894,494.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	380,356,962.31	700,686,841.10
210101	Үндсэн цалин	235,514,523.10	455,699,844.99
210102	Нэмэгдэл	46,433,670.27	116,510,196.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,122,518.18	53,792,500.00
210104	Урамшуулал	57,286,250.76	74,684,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,083,437.22	88,089,845.31
210201	Тэтгэврийн даатгал	32,812,897.38	59,769,977.66
210202	Тэтгэмжийн даатгал	3,850,634.98	7,019,032.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,045,308.01	3,793,795.35
210204	Ажилгүйдлийн даатгал	761,326.95	3,496,316.07
210205	Эрүүл мэндийн даатгал	7,613,269.90	14,010,724.15

Хөвсгөл аймгийн биеийн тамир, спортын хорооны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	183,426,042.62	188,799,999.77
210301	Гэрэл, цахилгаан	7,977,246.40	10,800,000.00
210302	Түлш, халаалт	168,317,518.22	171,999,999.77
210303	Цэвэр, бохир ус	7,131,278.00	6,000,000.00
210304	Байрны түрээс		-
2104	Хангамж, бараа материалын зардал	13,566,020.00	9,979,968.94
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,177,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	2,452,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,337,500.00	1,177,918.94
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	280,000.00	550,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,248,520.00	4,622,350.00
2105	Нормативт зардал		
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,996,945.00	45,759,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,296,945.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		-
210604	Урсгал засвар		-
2107	Томилолт, зочны зардал	48,700,000.00	45,759,000.00
210702	Дотоод албан томилолт	2,944,000.00	2,502,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,944,000.00	2,502,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,003,702.00	6,189,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	30,000.00	2,832,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	540000	529,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	117,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	49,500.00	17,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	33,000.00	32,400.00
210807	Газрын төлбөр	476,000.00	485,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	262,269,300.00	293,887,839.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	262,269,300.00	293,887,839.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,800,000.00	16,969,431.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,800,000.00	10,067,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		7,321,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800,000.00	2,746,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,883,721.65
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		5,883,721.65
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,017,910.23
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		441,000.23
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		576,910.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>60,139,190.85</u>	<u>5,649,800.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>48,392,055.00</u>	5,649,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	48,392,055.00	5,649,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	48,392,055.00	5,649,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	48,392,055.00	5,649,800.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(48,392,055.00)</u>	(5,649,800.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	11,747,135.85	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	47,500.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/ Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	907,978,900.00	902,373,354.35	5,605,545.65	99.4%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	907,978,900.00	902,373,354.35	5,605,545.65	99.4%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	897,910,300.00	892,305,554.35	5,604,745.65	99.4%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	643,131,400.00	638,698,441.10	4,432,958.90	99.3%
210101	Үндсэн цалин	382,666,100.00	383,695,157.33	(1,029,057.33)	100.3%
210102	Нэмэгдэл	184,443,200.00	126,526,483.77	57,916,716.23	68.6%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,185,900.00	53,792,500.00	(19,606,600.00)	157.4%
210104	Урамшуулал	41,836,200.00	74,684,300.00	(32,848,100.00)	178.5%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,391,500.00	80,366,755.31	24,744.69	100.0%
210201	Тэтгэврийн даатгал	54,666,200.00	54,500,963.66	165,236.34	99.7%
210202	Тэтгэмжийн даатгал	6,431,300.00	6,411,878.08	19,421.92	99.7%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,215,700.00	3,490,218.35	(274,518.35)	108.5%
210204	Ажилгүйдлийн даатгал	3,215,700.00	3,192,739.07	22,960.93	99.3%
210205	Эрүүл мэндийн даатгал	12,862,600.00	12,770,956.15	91,643.85	99.3%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал				
210301	Гэрэл, цахилгаан				
210302	Түлш, халаалт				
2104	Хангамж, бараа материалын зардал	9,158,600.00	8,559,119.94	599,480.06	93.5%
210401	Бичиг хэрэг	1,177,200.00	1,177,200.00	-	100.0%
210402	Тээвэр, шатахуун	2,452,500.00	2,452,500.00	-	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,506,800.00	945,919.94	560,880.06	62.8%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	588,600.00	550,000.00	38,600.00	93.4%
2105	Нормативт зардал				
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл				
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,689,800.00	5,649,800.00	40,000.00	99.3%
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,689,800.00	5,649,800.00	40,000.00	99.3%
210602	Тавилга				
210604	Урсгал засвар				
2107	Томилолт, зочны зардал	2,943,000.00	2,502,000.00	441,000.00	85.0%
210702	Дотоод албан томилолт	2,943,000.00	2,502,000.00	441,000.00	85.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,467,100.00	5,400,600.00	66,500.00	98.8%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,452,500.00	2,452,500.00	-	100.0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	529,700.00	529,700.00	-	100.0%
210803	Даатгалын үйлчилгээ	117,700.00	117,700.00	-	100.0%

Хөвсгөл аймгийн биеийн тамир, спортын хорооны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	78,500.00	17,500.00	61,000.00	22.3%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	32,400.00	32,400.00	-	100.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	490,500.00	485,000.00	5,500.00	98.9%
210807	Газрын төлбөр	1,765,800.00	1,765,800.00	-	100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	151,128,900.00	151,128,838.00	62.00	100.0%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	151,128,900.00	151,128,838.00	62.00	100.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-	-	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,068,600.00	10,067,800.00	800.00	100.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,068,600.00	10,067,800.00	800.00	100.0%
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,321,800.00	7,321,800.00	-	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,746,800.00	2,746,000.00	800.00	100.0%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	907,978,900.00	902,373,354.35	5,605,545.65	99.4%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	907,978,900.00	902,373,354.35	5,605,545.65	99.4%
310001	Улсын төсвөөс санхүүжих	907,978,900.00	902,373,354.35	5,605,545.65	99.4%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-		
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.0%
610001	Төсвийн байгууллага	1	1		100.0%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	27	27		100.0%
620001	Удирдах ажилтан	1	1		100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14		100.0%
620003	Үйлчлэх ажилтан	12	12		100.0%

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	235,000,000.00	234,558,999.77	441,000.23	99.8%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	235,000,000.00	234,558,999.77	441,000.23	99.8%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	235,000,000.00	234,558,999.77	441,000.23	99.8%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	188,800,000.00	188,799,999.77	0.23	100.0%
210301	Гэрэл, цахилгаан	10,800,000.00	10,800,000.00	-	100.0%
210302	Түлш, халаалт	172,000,000.00	171,999,999.77	0.23	100.0%
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.00	6,000,000.00	-	100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,200,000.00	45,759,000.00	441,000.00	99.0%
210604	Урсгал засвар	46,200,000.00	45,759,000.00	441,000.00	99.0%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	235,000,000.00	234,558,999.77	441,000.23	99.8%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	235,000,000.00	234,558,999.77	441,000.23	99.8%

310001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	235,000,000.00	234,558,999.77	441,000.23	99.8%
---------------	---	----------------	----------------	------------	-------

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/ Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	214,679,740.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	214,679,740.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	214,679,740.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	61,988,400.00
210101	Үндсэн цалин	57,738,571.80
210102	Нэмэгдэл	757,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,723,090.00
210201	Тэтгэврийн даатгал	5,269,014.00
210202	Тэтгэмжийн даатгал	607,154.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	303,577.00
210204	Ажилгүйдлийн даатгал	303,577.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,239,768.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,188,850.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,188,850.00
210702	Дотоод албан томилолт	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	408,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	
210807	Газрын төлбөр	408,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,371,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	143,371,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	
2132	Бусад урсгал шилжүүлэг	
300011	Орлого төвлөрүүлэлт	576,910.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	215,256,650.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	215,256,650.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	201,695,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,076,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,485,650.00

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт бараа материал, цалин, үндсэн хөрөнгийн тайлагналтай холбоотой нийт 1,558,262.0 мянган төгрөгийн 16 алдаа илэрснээс аудитын явцад 1,549,632.2 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 8,629.8 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 2 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 9 зөвлөмж хүргүүлэв.

Залруулсан алдаа:

- Машин тоног төхөөрөмж дансанд бүртгэлтэй 88-480 кодтой 639.9 мянган төгрөгийн өртөг бүхий 1 ширхэг Epson L3256 принтерийн ашиглалтын хугацаа оруулаагүй, 89-481 кодтой 1,049.9 мянган төгрөгийн Epson L8058 принтерийн ашиглалтын хугацааг 43 жилээр оруулсны улмаас элэгдэл буруу тооцогдсон байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан журмын 10 дахь хэсгийн 10.24-т "Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлнэ.", 10.23-т Хөрөнгийн ашиглалтын

хугацаа нь байгууллага тухайн хөрөнгийг ашиглахаар хүлээгдэж буй хугацаа, эсхүл тухайн хөрөнгийг ашиглан үйлдвэрлэхээр хүлээгдэж буй бүтээгдэхүүний хэмжээ, түүнтэй адилтгах нэгж юм." гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

- Тайлант онд худалдан авч бэлтгэсэн 754 ширхэг 19,600.0 мянган төгрөгийн сандал, 3,600.0 мянган төгрөгийн 1 металл хаалга, 2,600.0 мянган төгрөгийн майхныг үндсэн хөрөнгөд бүртгэлгүй, бараа материалын дансанд бүртгэсэн байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", СС-ын 229-р тушаалаар батлагдсан журмын 10.6.Хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж, үндсэн хөрөнгийн тодорхойлолтод нийцсэн бөгөөд байгууллагын хэрэгцээнд ашиглах, бусдад түрээслүүлэх зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээнээс 20,460.2 мянган төгрөгийн 2 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нийлүүлэгчийн нэр, хаяг байршуулахад 10 байгууллагын 329,682.3 мянган төгрөгийн мэдээлэл, орлогын гүйлгээнээс 1,173,232.1 мянган төгрөгийн 43 мэдээллийг цахим системд байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" 6 дугаар зүйлийн 6.4." Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4.-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;" 6.4.5.-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

• 3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Тайлант онд байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй спорт заалыг бусдад түрээслүүлсэн 3,750.5 мянган төгрөгийг орлогыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.4-т "бүх орлого", 14.4.5-т "бүх зардал"-г нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ мөн Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.6.10.-д "Төсвийн байгууллага нь мөнгөн касс бэлнээр хүлээн авсан үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг шууд захиран зарцуулах эрхгүй бөгөөд ажлын дараагийн өдөрт багтаан төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төлбөрийн акт тогтоох

Илрүүлэлт Байгууллагын спорт заалыг бусдад түрээслүүлсэн орлогоос "Заал зохион байгуулагч" гэсэн үндсэн орон тооны ажилтанд 10 хувийг эрх зүйн акт, тушаал шийдвэргүйгээр мөнгөн олговор олгосон байна. Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.1.Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4.-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна". гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа бөгөөд "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төлбөрийн акт тогтоох

3.2 Албан шаардлага

- Илрүүлэлт: Байгууллагын биет бус хөрөнгийн дансанд байгаа газар эзэмших гэрчилгээ дээрх 34574 м.кв талбайг биет бус хөрөнгийн дансанд тоон мэдээлэлгүй өртгийг

бүртгэсэн гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.1.1 үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх зэрэг заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн албан шаардлага: Анхан шатны баримтын хүрээнд бүртгэлд тусгах

Илрүүлэлт: Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээнээс 20,460.2 мянган төгрөгийн 2 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нийлүүлэгчийн нэр, хаяг байршуулахад 10 байгууллагын 329,682.3 мянган төгрөгийн мэдээлэл, орлогын гүйлгээнээс 1,173,232.1 мянган төгрөгийн 43 мэдээллийг цахим системд байршуулаагүй, 11 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" 6 дугаар зүйлийн 6.4." Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4.-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;" 6.4.5.-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн албан шаардлага: Шилэн дансанд байршуулах мэдээ, мэдээллийг хугацаанд нь бүрэн гүйцэд байршуулах

3.3 Зөвлөмж

- Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:
- **1. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг ирүүлэхдээ иж бүрдлийг хангаагүй, тайлангийн тодруулга, толилуулгыг бэлтгээгүй, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт болон дансны үлдэгдлийн баталгаа зэргийг ирүүлээгүй. / Тооцоог үнэн зөв нийлээгүйгээс тайланд өр төлбөр дутуу тайлагнасан/. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5-т "санхүүгийн тайлангийн тодруулга", Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4-т "Санхүүгийн нэгтгэсэн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 54.5-т "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна" гэсэн заалтууд болон "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна. Аудитын хугацаанд залруулсан болно.

2. Зардлын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сангийн сайдын баталсан эдийн засгийн ангиллыг зөрчиж 51,047.5 мянган төгрөгийн шатахуун, 11,442.5 мянган төгрөгийн хоолны зардал, 19,179.6 мянган төгрөгийн албан томилолт, 128,734.5 мянган төгрөгийн шагнал урамшууллын зардал гаргасан, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллах

3. Татвар, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд спортын амжилт гаргасан тамирчдад олгосон шагнал урамшуулал болон шүүгчийн ажлын хөлсөнд 128,734.5 мянган төгрөг олгосноос 6,435.7

мянган төгрөг суутгахаас 3,160.4 мянган төгрөгийг суутган шилжүүлж, 3,276.3 мянган төгрөгийг суутгаагүй байна. Энэ нь Хувь Хүний Орлогын Албан Татварын тухай хуулийн 19.1.1.урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай, шагнал болон тэдгээртэй адилтгах бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогыг 5 хувиар, 25.4

"Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Суутгавал зохих татварыг суутгаж, татварт төвлөрүүлэх

4. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

- Илрүүлэлт: Худалдан авалт хийхдээ харьцуулалтын арга хэрэглэлгүйгээр Сод монгол групп ХХК-тай шууд гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 53,500.0 мянган төгрөгийн шатахуун, 6 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас 29,859.5 мянган төгрөгийн 3300 ширхэг шагналын медаль худалдан авалт хийсэн байна. ТБОНӨХБАҮХАТХуулийн 34 дүгээр зүйл "Харьцуулалтын арга", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-г мөрдөж ажиллаагүй байна. Мөн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Босго үнийг баримтлан, худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулах

5. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авах ажиллагааны гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул, гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээ, худалдан авах бараа материалын нэр төрөл тоо хэмжээ тодорхойгүй, төлбөрийн мөнгөн дүнг тусгадаггүй, гэрээ байгуулсан этгээдийн гарын үсгийн тайлал байхгүй, гэрээг дүгнээгүй байна. ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 39.3.Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана: 39.3.1.гэрээний үнэ; 39.3.2.гэрээний зүйл болон бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл; 39.3.3.төлбөрийн нөхцөл, хугацаа; 39.3.6.бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх хуваарь гэсэн заалтуудыг мөрдөөгүй мөн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдах, худалдан авах гэрээнд тусгах нөхцөлийг хангаж, гэрээг дүгнэж ажиллах

6. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалд дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 10 нэр төрлийн 769 ширхэг 63,466.3 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", СС-ын 229-р тушаалаар батлагдсан журмын 10.6.Хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж, үндсэн хөрөнгийн тодорхойлолтод нийцсэн бөгөөд байгууллагын хэрэгцээнд ашиглах, бусдад түрээслүүлэх зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгө, бараа материалын дансны ангиллыг мөрдөж ажиллах

7. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шатахуун болон бараа материалын тайлан гаргаагүй, сар бүр хянаж баталгаажуулаагүй, шатахуун зарцуулалтыг шалгахад шатахуун зарцуулалтад норм нормативыг баримталж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, ЗТХС-ын 2019 оны 390 тушаалаар батлагдсан "Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-г дагаж мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын тайланг сар бүр гаргаж, баталгаажуулах, шатахуун зарцуулалтад норм нормативыг баримталж ажиллах

8. Төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болж байгаа спорт заалны түрээсийн орлого нь тогтмол давтамжтай орлого байтал төлөвлөгөөнд тусгалгүй, тайлант хугацаанд олсон 5,485.6 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар авч зарцуулсан байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4.-т "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх.", 44 дүгээр зүйлийн 44.4.-т "Туслах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг төсвийн жилийн дундуур авсан бол түүний төсвийг нэмэлт төсөв хэлбэрээр, бусад тохиолдолд тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ." гэж заасны дагуу туслах үйл ажиллагааны орлогыг төсвийн төлөвлөгөөнд төлөвлөж ажиллаагүй бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн үйл ажиллагааны орлогыг төсвийн төлөвлөгөөнд тусгаж, батлуулах

9. Ахмадын сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ахмадын сан: Биеийн тамир, спортын хороо нь ахмадын сан байгуулаагүй байна. Ахмадын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 7-р заалт, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ахмадын сан байгуулж, журмын дагуу ажиллуулах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				
					Залруулсан		Залруулаагүй		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	

Машин тоног төхөөрөмж дансанд бүртгэлтэй принтерийн ашиглалтын хугацааг буруу оруулсны улмаас элэгдэл буруу тооцогдсон байна.	1	457.6	1	457.6	1	457.6		
Тайлант онд худалдан авч бэлтгэсэн 754 ширхэг 19,600.0 мянган төгрөгийн сандал, 3,600.0 мянган төгрөгийн 1 металл хаалга, 2,600.0 мянган төгрөгийн майхныг үндсэн хөрөнгөд бүртгэлгүй, бараа материалын дансанд бүртгэсэн байна.	1	25,800.0	1	25,800.0	1	25,800.0		
Шилэн дансанд мэдээллийг дутуу байршуулсан байна.	1	1,523,374.6	1	1,523,374.6	1	1,523,374.6		
Дүн	3	1,549,632.2	3	1,549,632.2	3	1,549,632.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн үйл ажиллагааны орлогыг төрийн сангийн дансанд тушаагүй нягтлан бодох бүртгэлд тусгаагүй зарцуулсан.	1	3,750.5				
Байгууллагын спорт заалыг бусдад түрээслүүлсэн орлогоос "Заал зохион байгуулагч" гэсэн үндсэн орон тооны ажилтанд 10 хувийг эрх зүйн акт, тушаал шийдвэргүйгээр мөнгөн олговор олгосон байна.	1	315.0				
Байгууллагын биет бус хөрөнгийн дансанд байгаа газар эзэмших гэрчилгээ дээрх 34574 м.кв талбайг биет бус хөрөнгийн дансанд тоон мэдээлэлгүй өртгийг бүртгэсэн гэсэн зөвлөмж хэрэгжүүлээгүй байна			1			
2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг ирүүлэхдээ иж бүрдлийг хангаагүй, тайлангийн тодруулга, толилуулгыг бэлтгээгүй, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт болон дансны үлдэгдлийн баталгаа зэргийг ирүүлээгүй. / Тооцоог үнэн зөв нийлээгүйгээс тайланд өр төлбөр дутуу тайлагнасан/					1	1,288.0
Тайлант хугацаанд спортын амжилт гаргасан тамирчдад олгосон шагнал урамшуулал болон шүүгчийн ажлын хөлсөнд 128,734.5 мянган төгрөг олгосноос 6,435.7 мянган төгрөг суутгахаас 3,160.4 мянган төгрөгийг суутган шилжүүлж, 3,276.3 мянган төгрөгийг суутгаагүй байна.					1	3,276.3
Нийт бараа материалд дансанд 10 нэр төрлийн 63,466.3 мянган төгрөгийн 769 ширхэг үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэлтэй байна.					1	

Шатахуун болон бараа материалын тайлан гаргаагүй, сар бүр хянаж баталгаажуулаагүй, шатахуун зарцуулалтыг шалгахад шатахуун зарцуулалтад норм нормативыг баримталж ажиллаагүй байна.					1	
Орлогыг төлөвлөлтийг үнэн зөв бодиттой төлөвлөхгүй байна. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болж байгаа спорт заалны түрээсийн орлого нь тогтмол давтамжтай бөгөөд тайлант хугацаанд 5,485.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна					1	
Сангийн сайдын баталсан эдийн засгийн ангиллыг зөрчиж 51,047.5 төгрөгийн шатахуун, 11,442.5 төгрөгийн хоолны зардал, 19,179.6 төгрөгийн албан томилолт, 128,734.5 төгрөгийн шагнал урамшууллын зардал гаргасан, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй.					1	
Дүн	2	4,065.5	1	-	6	4,564.3

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээнээс 20,460.2 мянган төгрөгийн 2 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нийлүүлэгчийн нэр, хаяг байршуулахад 10 байгууллагын 329,682.3 мянган төгрөгийн мэдээлэл, орлогын гүйлгээнээс 1,173,232.1 мянган төгрөгийн 43 мэдээллийг цахим системд байршуулаагүй байна.	1				1	-		
Худалдан авах ажиллагааны гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул, гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээ, худалдан авах бараа материалын нэр төрөл тоо хэмжээ тодорхойгүй, төлбөрийн мөнгөн дүнг тусгадаггүй, гэрээ байгуулсан этгээдийн гарын үсгийн тайлал байхгүй, гэрээг дүгнээгүй байна.	1	-					1	-
Худалдан авалт хийхдээ харьцуулалтын арга хэрэглэлгүйгээр Сод монгол групп ХХК-тай гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 53,500.0 мянган төгрөгийн шатахуун, 6 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас 29,859.5 мянган төгрөгийн 3300 ширхэг шагналын медаль худалдан авалт хийсэн байна.	1	-					1	
Ахмадын сан байгуулаагүй	1	-					1	-
Дүн	4	-			1		3	-